

“ӨНГӨ” ХЭМЭЭХ МЭДЭГДЭХҮҮНИЙГ ТАНИН МЭДЭХ АСУУДАЛД

Т. Булган (Доктор Ph.D)
А.Баасансүрэн (Магистрант)
Философи, шашин судлалын тэнхим, МУИС

Түлхүүр үг: “Цагаан үүл цагаан уу?”, **Өнгө дүрс хэмээх мэдэгдэхүүн, түүний мөн чанар, ялгал, тусгал, логик мэтгэлцээ, оршихуйн өнгө**”

Товч утга: Буддын философийн танин мэдэхүйн судлалд мэдэгдэхүүн (phenomena)¹ хэмээх ойлголт гол суурь эзлэх бөгөөд энэхүү суурь мэдэгдэхүүнийг танин барихын тулд юуны өмнө түүний мөн чанар, ялгалыг танин мэдэх, улмаар буй ба буй бус мэдэгдэхүүн, мөн ба биш хэмээх ойлголт, няцлага ба бүтээхүйн утга, нэг ба тус тус утга, шалтгаан ба үр дагавар, орон ба оронт, ерөнхий ба тусгаар, харилцах ба барилдах, бэлгэ чанар ба бэлгэдэлт, гурван цаг, өөрийн ба ерөнхий бэлгэ чанар, ном хаялцах арга ухаан, учир шалтгааны гаргалгаа, нотлолууд зэрэг танин мэдэхүйн олон аспектиудыг авч үздэг билээ.

Буддын логикт авч үздэг суурь мэдэгдэхүүний нэг бол “Өнгө” (colour) ²хэмээх мэдэгдүүнийг авч үзжээ. Учир өнгө дүрс бол хүний харах эрхтэн, харааны мэдрэхүй зэргээр мэдрэгддэг суурь мэдэгдэхүүн бөгөөд хүний танин мэдэхүйн анхдагч тусгал орон (object) гэж үздэг. Энэ талаар Энэтхэгийн гүн ухаантан Будда багш өөрөө болон түүний залгамжилсан хожуу үеийн сэтгэгчид өөрсдийн бүтээл туурвилаараа зохих ёсоор авч үзэж тайлбарлажээ.

Үүний нэг жишээ болгож ХХ зууны эхэн үеийн Монголын буддын сэтгэгчдийн нэг Их хүрээний гавж Лувсандашийн “Дүйра онцар гаадон”³ буюу “Сонин гайхамшигт номын хурим” хэмээх гүн ухааны зохиолоос дээрх асуудлыг тодотгон авч үзэхийг бид хичээлээ.

Уг зохиолын эхэнд Өнгө дүрс хэмээх мэдэгдэхүүнийг дараах гурван хүрээнд авч үзсэн байна. Үүнд: 1. “Бусдын ёсыг хорих” 2. “Өөрийн ёсыг байгуулах” 3. “Эсэргэцлийг няцаах”⁴ эдгээр болно. Энэ гурван хүрээ бол ерөнхийдээ буддын гүн

ухааны аль ч ёсонд гүн ухааны асуудлыг шалгаж үздэг дүгнэдэг нийтлэг арга зүйн хүрээ гэж тооцогддог.

Энд өгүүлж буй “Бусдын ёс”, “Өөрийн ёс” гэдэг ном хаялцах буюу философи мэтгэлцээн өрнүүлж байгаа эсэргэлдэгч хоёр этгээдийг(буддын бус ба буддын философи) илэрхийлж байгаа, мөн түүний дээр “эсэргэцлийг няцаах” гэдэг нь гуравдагч этгээд буюу тэднээс гаргсан асуудалд хариу өгч зөв ойголт өгөх, “өөрийн ёсоо хамгаалах” зэрэг танин мэдэхүйн хүрээг хамарч байна.

1.Бусдын ёсыг хорих ёс: Уг зохиолд өнгө дүрсний талаар “Өнгө мөн болоход Цагаан байх албатай”, “Өнгө мөн болоход Улаан байх албатай”, “Өнгө мөн болоход Язгуурын өнгө байх нь албатай” гэх, мөн түүнчлэн “Дүрс мөн болоход Өнгө байх албатай”, “Өнгө мөн болоход Хэлбэр байх нь албатай”, “Өнгө мөн болвол Гишүүн өнгө мөн байх албатай” гэх зэргээр бусдын зүгээс асуулт тавьж мэтгэлцээн (philosophical debate) өрнүүлнэ. Бид өөрийн талыг А гээд бусдын талыг Б гэж тэмдэглэсү. Жишээ нь:

Энд Б: **“Өнгө мөн болоход Цагаан байх албатай”** гэсэн баримтлалтай байна. Өнгө л болвол цагаан байна гэж үздэг хүн байх аж. Өөрөөр хэлбэл ганцхан цагаан өнгө оршино. Бусад өнгийг үгүйсгэгч

¹ 20-23 тал, Лувсандаш: Сонин гахймшигт номын хурим? УБ2009

С. Янжинсүрэн: Зава Дамдин: Дүйра зацэгийн шинжлэл,

³ Лувсандаш гавжийн зохиолын гүвд нэр, ер нь тү: “Дүйра, монг: “Хураангуй сургууль” буюу Учир шалтгааны ухааны судлагдахууныг хураангуйлж нэгтгэсэн зохиол,

⁴ Гурван ёс- буддын гүн ухааны мэдлэг олох арга шалгуурууд

нэгэн. Ийм хүнд өөр өнгө байдгийг хэрхэн ойлгуулах вэ? Чингээд дараах байдлаар

А: “Бадмаарагийн өнгө байна. Энэ чинь цагаан өнгө болох уу, Өнгө мөн шүү дээ?” гэсэн бодомж асууя. Эсэргэлдэгч бусад бээр авсан жишээг/юмсын нэр, терм/ эсэргүүцсэн хариу өгвөл, юу гэсэн утга гарах бол. Хэрвээ эсэргэлдэгч үүнийг цагаан өнгө мөн гэвэл:

А: “Бадмааргийн өнгө чинь Цагаан биш ээ. Улаан өнгөтэй шүү дээ”

Б: Үгүй ээ, тэр чинь Улаан биш,...

А: Бадмаараг Улаан мөн. Улаан гэж хардаг хүн байна

Б. Байхгүй

А: Байна, Түүнийг улаан өнгийг хардаг нүд байна шүү дээ... г.м

Үүний хариуд өөрийн ёсныхон эдгээр ойлголтуудын буруу ташаа байдлыг засаж, өөрийн ёсны эерэг зөв гаргалгаа, нотолгоонуудыг учир шалтганы үүднээс эргүүлэн гагаж тавих замаар бусдын ёсыг хорих буюу эл асуудалд зөв шийдэл зөв ойлголтыг эсэргэлдэгч этгээдэд төрүүлэх, мунхаг буруу ойлголтыг засах ач холбогдолтой.

2. Өөрийн ёсыг байгуулах: Үүний дараа “Өөрийн ёсыг байгуулах” буюу эл аспектийн талаарх өөрийн баримтлалаа гаргаж тавина. Ж.нь: Өнгө гэж юу болох, түүний мөн чанар, ялгал, шалгуур зэрэг тодорхойлолтуудыг учир шалтгааны үүднээс гаргаж илэрхийлэх гэм мэтчилэн байна. Дээрх зохиолд Өнгө хэмээх аспектиг авч үзэхдээ “дүрсийн мэдрэхүй” тэргүүтэний таван төрөн түгэхүй хэмээх таван мэдрэхүйн хүрээнд авч үзсэн байдаг. Чингэхдээ “Дүрс төрөн түгэхүй бол харааны мэдрэхүйн баригдахуун орон мөн” гэж ерөнхий томъёолоод “Өнгө болон хэлбэр” бол түүнд хамаарагдах, түүний хүрээнд багтах мэдэгдэхүүн мөн” гэж үзжээ. Үүнийгээ Энэтхэгийн эрдэмтэн Дигнага⁵, Дхармакирти⁶, Вахсубандху⁷ зэрэг эрдэмтдийн бүтээлээс эш авч нотолсон үзэгдэнэ. Лувсандаш гавж уг зохиолдоо:

⁵ Буддын учир шалтгаан, логик танин мэдэхүйн ухааныг хөгжүүлсэн Энэтхэгийн эрдэмтэн, Шалгадагийн судар зэрэг шастир туурвижээ.

⁶ Мөн дээрх чиглэлийн ухааныг хөгжүүлсэн Энэтхэгийн эрдэмтэн, Праманасаучаяа зэрэг шастир туурвижээ

⁷ Илт номын сан (Abhidharmakosa) шастрыг зохиогч

«Өнгө» хэмээх мэдэгдэхүүний үест: Дүрс дор болох нь түүний мөн чанар бөгөөд “Дундад орохуй” (Madhyamakavatara)-ээс Хэлбэр нь дүрс болох мөн чанарт, хэлбэрт болох дүрсний билиг чанар мөн” хэмээжээ. Дүрсийг гадаад дүрс, дотоод дүрс гэж хоёр ангилна. Гадаад дүрсийг: дүрсний төрөн түгэхүй, дууны төрөн түгэхүй, үнэрний төрөн түгэхүй, амтны төрөн түгэхүй, хүрэлцэхүйн төрөн түгэхүй гэж тав ангилж

1. Харах мэдрэхүйн баригдахуун нь дүрсний төрөн түгэхүйн мөн чанар
2. Соносох мэдрэхүйн баригдахуун нь дууны төрөн түгэхүйн мөн чанар
3. Үнэрлэх мэдрэхүйн баригдахуун нь үнэрний төрөн түгэхүйн мөн чанар
4. Амтлах мэдрэхүйн баригдахуун нь амтны төрөн түгэхүйн мөн чанар
5. Биений мэдлийн баригдахуун нь хүрэлцэхүйн төрөн түгэхүйн мөн чанар гэж тус тус илэрхийлсэн байна.

Өнгөний хувьд: “Өнгө болж буй тэр нь буюу” хэмээгээд Өнгийг ялгаваас Язгуурын болон Гишүүн өнгө гэж хоёр буй. Язгуурын өнгөнд Цагаан, Улаан, Хөх, Шар гэсэн үндсэн дөрвөн өнгө буй. Гишүүн өнгөнд Үүл, Утаа, Тоос Манан, Гэгээ, Харанхуй, Сүүдэр, Нарны гэрэл зэргийн найман өнгийг багтаан үзжээ.

Хэлбэрийг ялгахдаа Урт, Богино, Өндөр, Нам, Дөрвөлжин, Дүгрэг, Хатгай ба Хавтгай бус хэлбэр гэсэн найман зүйлийг багтаан үзжээ. Хэдийгээр энэ хоёр тус тусдаа ойлголт гэж тодорхойлсон ч өнгө хэлбэр хоёрын хоорондын нийлэмж ба тусгаар утгын талаар “дөрвөн өнцөгт бодомж”/Мүши/ гаргасан нь сонирхолтой бас бодууштай.

А. “Өнгө мөн болох ч Хэлбэр үл болох өнцөг”- “Цагаан Лавайн өнгө зэрэг”

Б. “Хэлбэр мөн боловч Өнгө үл болох өнцөг”- “Дөрвөлжин, дүгрэг г.м хэлбэрүүд”

В. “Өнгө Хэлбэр хоюул болох өнцөг”- “Үүл, Утаа, Тоос, Манан дөрөв”

Г. “Өнгө Хэлбэр алин ч биш болох өнцөг”- “Шороо, Ус, Гал, Хий дөрвөн махбодь”

3. Эсэргэцлийг няцаах ёс: “Цагаан Үүл Цагаан уу?”

Урьд гарсан бусдын ёсыг хорих болон Өөрийн ёсыг үзүүлэх хэмээхийг эзэмшсэн бол энэ зарчим нь хялбар бөгөөд бусдын ёс баримтлагч нарын хаяцаа эсэргэцлийг няцаахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл эндүү бодолтой бусдын эсэргэцэн асууж мэтгэлцэхийг зөвөөр өөрийн ёсны дагуу хариулж мөн асуухыг л эсэргэцлийг няцаах гэж ойлгож болно. Буруу үзлийг өөрийн дотоод үзлийн үүднээс тайлбарлаж буруу үзлийг няцаана.

Эсэргэлдэгч тал шинэ бодомжууд гаргаж тавина. “Цагаан үүл цагаан уу?” Цагаан морь цагаан уу?”, “Цагаан лавай цагаан өнгө үү? г.м. Логик нэр хэллэгтүд илэрхийллүүд ч гэмээр юм уу. Дашрамд дурдахад өрнийн философид Аристотель, Декарт, Лейбниц зэрэг сэтгэгчид логикийн хэл хэллэгийг бий болгосон талаар судлаач эрдэмтэд тэмдэглэжээ.⁸

Бидний ярилцан буй энэ асуудал дээр ч мөн адил буддын гүн ухааны танин мэдэхүй болон гүн ухааны нарийн хэлэлцээ буюу ном хаялцах үг хэллэг, утга санаагаа илэрхийлэх өвөрмөц арга барилтай хөгжиж ирсэн зэргийг энд цухас дурдсу.

А. “Цагаан үүлийг цагаан” гэвэл

Б: Цагаан үүл чинь өнгө болох уу?

А. Тийм

Б. Үгүй ээ, Тэр чинь Хэлбэр болно шүү

А. Хэлбэр болохгүй. Өнгө шүү.

Б. Гишүүн өнгө. Найман гишүүн өнгөний нэг болно гэж өөрийн ёсноо үздэг.

А. Гишүүн өнгө биш,

Б. Үүлийг чинь гишүүн өнгө гэж үзнэ.

Цагаан үүл чинь цагаан биз дээ

А. Үгүй. Цагаан биш гэвэл

Б. Цагаан гэж хардаг нүд байгаа биз дээ..

Энэ мэтээр цааш нь хөөсөөр байвал “Цагаан үүл цагаан биш, өнгө биш, бүр дүрс биш, тэгвэл жинхэнэ Үүл гэдэг ойлголт чинь юу болох вэ?” гэдэг асуулт дараагийн шатанд гарч ирж болно. “Дүрс гэдэг бол хүртэхүйн ертөнцийн тодорхой юмс үзэгдлийг тэмдэглэсэн хоосон чанарын эсрэг категори болно” гэж Нагаржуна нэгэнт тэмдэглэсэн ажгуу⁹.

Дүгнэлт: Өнгө дүрс хэмээх мэдэгдэхүүн нь буддын танин мэдэхүй төдийгүй учир шалтгааны мэдлэгт хүрэх суурь мэдэгдэхүүн мөн. Тэдгээр мэдэгдэхүүнийг танин мэдэх **”Бусдын ёсыг хорих”**, “Өөрийн ёсыг байгуулах” “Эсэргэцлийг няцаах” эл гурван ёс нь буддын танин мэдэхүйн мэдлэг олох чухал аргуудын нэгэн болж хөгжиж ирсэн байна. Монголын сэтгэгч Лувсандорж гавж нь эдгээр танин мэдэхүйн аргыг онол, арга зүйн талаас нарийвчлан хөгжүүлж буддын логик шинжилгээ, сэтгэлгээний хөгжилд хувь нэмэр оруулжээ.

НОМ ЗҮЙ:

1. Билгийн зүрхэн судар
2. Лувсандаш гавж: ”Сонин гайхамшигт номын хурим”, Хүрээ барын хуулбар УБ 2009
3. Г. Лувсанцэрэн: Дүрс, түүнийг танин барихуй”, Буддын гүн ухааны онол түүхийн асуудлаас УБ 2008
4. Т.Булган: Буддын философийн дэвтэр УБ 2010
5. Далай лам Данзанжамц: Буддын шашны шинжлэх ухаан ба үзэл онолын хураангуй боть 5 .УБ 2016
6. Т. Содномдаргиа: Буддийская тибетоязычная логика УБ 1999.
7. Дхармакирти: Шалгадгийн долоон шастир Г.Лувсанцэрэн, УБ 2000
8. Ч.Жүгдэр, З.Агваанбалдангийн гүн ухааны үзэл, УБ 1978
9. Jamyang Lama Choklha Oser:”The Logic Primer of Rato” New-York,U-SA 1992
10. М. Отгонбаяр: Логик МУИС, УБ 2016
11. С.Янжинсүрэн: “Зава ламын Дүйра зацэг зохиолын шинжлэл” УБ 2000
12. Монголын философийн түүх, (XVII-XIX ЗУУН) IV дэвтэр ФСЭХ .УБ 2001
13. Монголын философийн түүх, (XVII-XIX ЗУУН) III дэвтэр УБ 2001

⁸ М.Отгонбаяр, Логик УБ., 2017, 11-13 тал,

⁹ Г.Лувсанцэрэн: Дүрс хийгээд түүнийг танин барихуй, //Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас// УБ 2008., 73-

ABSTRACT

In this research article, we try to make little analyses on “the color and shape” which is considered as one of the basic aspects of Buddhist epistemology in the philosophical debate work by Lubsandash, Mongolian Buddhist thinker, XX century.

In this respect, we touched with the three main argument methods as “reputation others view”, “establish own view “ including definition and division etc, and “eliminating objections”. Concerning the aspects, we take one example on the reputation as following as,

Take the subject color of white conch shell- it follows it is red - because it is color. “You accepted the pervasion. If reason not established.” Take the subject color of white conch- shell it follows it is it is white. “If reason not established.” Take the subject color white conch shell - it follows it is white because it is one of with color white conch shell. If root is accepted. Take the subject color and - it follows it is not red- because it is white. If no pervasion- there is pervasion because: white and don't have a common base, because : the two are mutual exclusive.